

## Монгол дахь угсаатны асуудал: Дарвинизм, Панмонголизм, Зөвлөлтийн бодлого, төр

П.Мягмар

МУИС-ийн Түүхийн тэнхимийн багш

[myagmar@num.edu.mn](mailto:myagmar@num.edu.mn)

### Удиртгал

2019 онд Монгол улсын Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ)-наас эрхлэн хэвлүүлсэн ерөнхий боловсролын сургууль (ЕБС)-ийн *Нийгэм судлал X* сурах бичигт Монголын хүн ам нь 24 угсаатнаас бүрддэг болохыг хүснэгтлэн харуулж, тархалтыг нь Монгол улсын газрын зурагт өнгө ялган тэмдэглэжээ. “Монгол орны хүн амын угсаатны бүрэлдэхүүн” гэж гарчигласан хүснэгтээс үзвэл Монгол нь Халх, Казах, Дөрвөд, Баяд, Буриад, Захчин, Дарьганга, Урианхай, Дархад, Өөлд, Хотгойд, Торгууд, Хотон, Мянгад, Тува, Барга, Үзэмчин, Элжигэн, Сартуул, Хамниган, Цаатан, Узбек, Харчин, Цахар угсаатны орон ажээ (Алтанмандах нар 2019: 38-39). Хүснэгт болон газрын зургийн гарчигт “Монгол улс” бус, “Монгол орон” гэх нэршлийг хэрэглэжээ. “Орон” гэх үгийг төрт улсаас өөр утгаар ойлгож болох бөгөөд *Монгол хэлний их тайлбар толь*-д тодорхойлсноор энэ нь “амьдран суух газар”, “нутаг дэвсгэр” гэх утгыг бас илэрхийлдэг байна (Болд нар 2015). Тухайлбал, “халуун дулаан орон”, “монголчуудын орон” гэвэл тэрхүү “орон” нь халуун дулаан бүс нутаг, монголчуудын амьдардаг бүс нутгийг зааж буй газар зүйн ойлголт болно. Иймд дээрх хүснэгт, газрын зургийн гарчиг нь төрт улс, үндэстэн гэхээсээ Халх, Дөрвөд, Баяд, Буриад, Захчин зэрэг олон угсаатан аж төрдөг газар зүйн бүс гэх ойлголтыг өгнө.

Дээрх сурах бичигт Монгол нь 24 угсаатнаас бүрдсэн хүн ам бүхий орон болохыг тодорхойлсон нь зөвхөн сурах бичиг зохиогчдын үзэл, ойлголтын асуудал биш ажээ. Сурах бичгийн зохиогчид дээрх хүснэгтийн мэдээллийг Үндэсний статистикийн хорооны 2012 оны тайлангаас эшлэжээ (Алтанмандах нар 2019: 39). Энэ нь цаанаа төрөөс хөтлөн явуулдаг хүн амын албан бүртгэлийн асуудал болж хувирч байна. Л.Мөнх-Эрдэнийн (2012: 28) судалгаанаас үзвэл, 1930-аад оноос Монгол улсад засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг шинэчлэхдээ угсаатны ангиллыг нэвтрүүлж, хүн амыг тоолж паспортжуулсан бөгөөд бүртгэлийн уг категори нь өнөө хүртэл хэвээр байна. Зугаад жилийн өмнө нэвтрүүлсэн хүн амын бүртгэлийн тэрхүү бодлогыг Монгол улсад өнөө хүртэл ягштал баримтлан дагаж байгаа төдийгүй БШУЯ-наас хянан хэвлүүлсэн сурах бичгийн дагуу ЕБС-д системтэй зааж байна.

Л.Мөнх-Эрдэнэ Монгол улсын хүн амын бүртгэлийн бодлогыг “үндэстний эсрэг бүртгэлийн геноцид” гэж нэрлэжээ. Түүний шүүмжлэн бичсэн нь: “Монгол улс Монгол үндэстний эсрэг бүртгэлийн геноцид явуулсаар даруй 90 гаран жил болж байна. Монгол үндэстний үндэстэн-улс (nation-state) гэж үзэж болох Монгол улс гайхалтай нь Монгол үндэстнийг албан ёсоор хүлээн зөвшөөрдөггүй төдийгүй идэвхтэй үгүйсгэдэг. Монгол улсад албан ёсоор Монгол гэдэг үндэстэн байхгүй, нэг ч хүнийг албан ёсоор Монгол яс үндэс, үндэс угсаа, ястан, үндэстэн, тэдгээрийн албан ёсны орчуулга минзү (民族), *национальность*, *nationality*, *ethnicity* гэж хүлээн зөвшөөрдөггүй, бүртгэдэггүй. Жишээлбэл, Монгол улсын хүн ам, орон сууцны 2020 оны тооллогоор Улаанбаатар хотод Халх 1,321,660, Дөрвөд 28,712, Барга 602 гэх мэтээр нийт 31 “үндэс угсааг” бүртгэсэн байна. Дан ганц хүн амын тооллого биш шинээр төрсөн хүүхдийн бүртгэл, иргэний аливаа бүртгэл мэдээлэл, төрийн албан хаагчийн анкет зэрэг Монгол улсын бүх бүртгэл мэдээлэл дээр нэг ч Монгол үндэстэн, нэг ч Монгол хүн байхгүй” (Мөнх-Эрдэнэ 2025: 24).

Монгол нь нэгэн зууны өмнө орчин үеийн үндэстэн улс (modern nation-state) болсон гэх боловч албан ёсны бүртгэлд иргэд нь яагаад өнөө хүртэл монгол үндэстэн бус, харин орчин үеэс өмнөх (pre-modern) үеийн Халх, Буриад, Дөрвөд, Баяд, Захчин, Торгууд, Дарьганга, Урианхай гэх мэт тус тусдаа “угсаатан” хэвээр байна вэ? Тэд түүхийн хувьд нүүдэлч малчин гаралтай, нэгэн төрд харьяалагдаж ирсэн бөгөөд ихэнх нь хэл, соёлын ялгаа үгүй (байсан ч тэр нь багахан) боловч тэднийг яагаад тусдаа угсаатнууд хэмээн ангилах болсон бэ? Монгол нь олон угсаатны улс мөн гэх ойлголтыг хэн ямар онолоор судалж, ямар баримтаар нотолсон бэ?

Сүүлийн хориод жилд Д.Снийт, Л.Мөнх-Эрдэнэ нарын судалгаа дээрх асуултуудын хариултыг эрэлхийлж, олсон хариулт нь түүхнийгмийн шинжлэх ухаанд тогтсон ойлголтуудыг няцааж байна. Д.Снийт (2007) дарвинизмд суурилсан хувьслын (evolutionist) онолоор Монголын нийгмийг судалсан нь колоничлолын үзэл суртлын нөлөөтэй хавсран Монголд төргүй, ураг төрлийн нийгмийн үндсэн нэгж гэх “овгууд” (tribes)-ыг хэрхэн буй болгож, тэдгээр нь хожим Халх, Дөрвөд, Захчин гэх мэт “угсаатнууд” болсныг судалжээ. Ялангуяа Л.Мөнх-Эрдэнэ (2012) 1930-аад оноос Монголд хүн амыг олон “ястан”, “угсаатан” болгон категоржуулан бүртгэж, паспортжуулсны учир шалтгааныг тусгайлан шинжилжээ. Тэрээр нийгмийн хувьслын онолоор зэвсэглэсэн Зөвлөлтийн судлаачдын “угсаатан судлалын парадигм” (ethnological paradigm) Монголд хэрхэн нэвтэрч, Зөвлөлтийн угсаатны бодлого 1920-иод оны сүүлээс Монголд төрийн эрхийг барьсан зүүнтнүүдээр дамжин хэрхэн хэрэгжиж монголчуудыг “монголжуу”, Монголыг олон ястан, угсаатны улс болгосныг судалгаандаа харуулсан байна.

Л.Мөнх-Эрдэнэ монголчуудыг монголжуу, Монголыг олон ястан угсаатны улс болгосон нь “Монголын тусгаар тогтнолын ёгт үр дагавар” байсан гэх санааг судалгаандаа дэвшүүлжээ. Түүний бичсэн нь: “Тусгаар тогтнол, үндэсний төр улс дэлхий даяар үргэлж л үндэсний нэгдэл, нягтрал, ижилслийг төрүүлж, бэхжүүлж ирсэн түүхтэй. Чингисийн угсааныхан Монголын тусгаар тогтнолыг тунхаглахдаа ч чухам тийм үзэл баримтлалтай байсан ажээ. Гэвч Монголын тусгаар тогтнолыг удирдсан Чингисийн угсаа залгамжлал их гүрнүүдийн өмнө хүчин мөхсдөж, түүхийн тавцанаас арчигдахын хамт хэдэн зууныг дамнуулан авч ирсэн улс орон, газар нутаг нь хэсэгчлэн хэрчигдсэн байна. Түүгээр ч барахгүй ёгттой нь тэдний улс төрийн үзэл баримтлалыг халсан шинжлэх ухааны нэр хүндэд тулгуурласан, Европын зах хязгаарын харц дордосын үзэл Монголыг угсаатны зүйн категори болгосон төдийгүй Чингисийн угсааныхны эзэмшлүүдийг овог, аймаг, ястан болгож, тэгснээрээ Чингисийн угсааны хунтайж нарыг овог аймгийн удирдагчид болгожээ. Тархай бутархай ч тусгаар тогтнол, эзэн эрхээ алдаагүйсэн бол Чингисийн угсааныхан Монголыг засагласан хэвээр ч байсан байж магадгүйн дээр Монгол эсвэл Монголчууд Герман хэлтэй ард түмнүүдийн нэгэн адил холбооны болон хэд хэдэн тусгаар тогтносон төр улсууд ч байсан байж болох юм” (Мөнх-Эрдэнэ 2012: 36-37) гэсэн байдаг.

Энэ өгүүлэл нь Монголын тусгаар тогтнолын тэрхүү ёгт үр дагавартай холбоотойгоор Монгол дахь угсаатны асуудлыг дарвинизм, XX зууны эхээр Монголыг онилсон их гүрнүүдийн гео улс төр, панмонголизм, Чингисийн угсааны ноёдын тусгаар тогтнолын тэмцэл, өнөөгийн Монгол дахь үндэсний ижилслийн ойлголтыг тодруулахыг зорив.

### **Дарвинизм “бүдүүлэг үедээ гацсан” угсаатнуудыг төрүүлсэн нь**

Монголыг олон угсаатны улс болгох үзэл нь XX зууны эхээр мэндэлжээ (Снийт 2007; Мөнх-Эрдэнэ 2012). Л.Мөнх-Эрдэнийн (2012: 28-29) судалгаанаас үзвэл 1930-аад онд БНМАУ-д 30 орчим ястан буюу угсаатны бүлэг, хэдэн зуун овог, аман аялгуу бүртгэгджээ. Түүх, угсаатан судлалын хүрээнд уг ойлголт нь XX зууны эхээр Оросоор дамжин Монголд нэвтэрсэн орчин цагийн Өрнөдийн нийгмийн шинжлэх ухааны онолоос эхтэй ажээ. XIX зуунаас Өрнө дахинд шинээр хөгжсөн нийгмийн шинжлэх ухаанд байгалийн шинжлэх ухааны онол, загварыг зээлдэн хэрэглэж, хүний нийгмийн зүй тогтлыг таних, тайлбарлах гэсэн оролдлого их гарч байжээ. Тэдгээрийн нэг нь тухайн үедээ байгалийн ухаанд ихэд шуугиан тарьж, амжилт олсон биологийн хувьслын онол буюу дарвинизмаар хүний нийгмийг тайлбарлах оролдлого байв. XIX зууны сүүл үед Чарльз Дарвины хувьслын онол нь тухайн үед хөгжиж эхэлж байсан соёлын антропологид хүчтэй нөлөө үзүүлж, давамгайлах байдалтай болжээ. Биологийн төрөл зүйлс нь

түүхийн явцад ганц эст эгэл бүдүүлэг биет байснаас сүүн тэжээлтэн, түүний дотор оюун ухаант хүн хүртэл нарийсан хувьссан гэх хувьслын онолын санааг соёлын антропологичид авч хэрэглэхдээ соёл ба нийгэм нь түүхэн явцад эгэл бүдүүлэг төлөв байдлаас нарийн хөгжингүй соёл иргэншлийн шат руу хувьсдаг гэж үзээд, өөрсдийн ажиглан судалсан нийгмүүдийг түүхэн хувьслын аль нэг үе шатанд оруулж тайлбарлах болсон байна.

XIX зууны антропологичдын ажигласнаар, Өрнө дахины нийгэм нь түүхэн хувьслын үр дүнд орчин цагийн иргэншлийн шатанд хүрсэн бол Дорно дахины нийгмүүд нь орчин үежилтээс өмнөх бүдүүлэг үедээ гацсан байдалтай, эсвэл хувьслын дээд шатанд хүрээгүй байжээ. Ялангуяа тэдний нүдэнд Төв Азийн монгол мэтийн нүүдэлчин ард түмэн нь төр ба засаг захиргаа үүсэхээс өмнөх балар үеийн нийгмийн зохион байгуулалт болох ураг төрлийн байгууллыг хадгалж үлдсэн нь түүхийн өвөрмөц жишээ болж харагдсан байна. Европын түүх, нийгэм судлаачид XIII зуунд Чингисийн угсааныхан их байлдан дагууллаар дэлхийд урьд байгаагүй том эзэнт гүрний удирдагчид болсныг сурвалж, нотолгоонд баригдан хүлээн зөвшөөрдөг боловч нийгмийн хөгжлийн хувьд монголчууд нь түүхийн зэрлэг бүдүүлэг шатанд гацсаар Европын колоничлолыг үзсэн Умард Америкийн индианчуудаас нэг их дээрдэхгүй ард түмэн гэж үзжээ.

Антропологич Л.Х.Морган (1877) *Эртний нийгэм* бүтээлдээ хүн төрөлхтний нийгмийг түүхэн хувьслаар нь “зэрлэг”, “бүдүүлэг”, “иргэншилт” гэсэн гурван үндсэн шатанд хуваасан байна. Тэр бээр Умард Америкийн индианчуудын нийгмийг ажигласан судалгаандаа иргэншил, төр үүсэхээс өмнөх Европын зэрлэг, бүдүүлэг нийгэм нь индианчуудынхтай адил байсан гэж үзжээ. Түүний ажигласнаар ирокез индианчуудын нийгмийн зохион байгуулалтын үндсэн нэгж нь эцгийн шугам дагасан ураг төрлийн нэгдэл байжээ (Morgan 1877: 105-118). Антропологичид тэрхүү нэгдлийг “трайб” (tribe) хэмээх латин гаралтай үгээр нэрлэсэн ажээ. Хожим Монголыг судлагч эрдэмтэд уг нэр томъёог монгол хэлэнд “овог” хэмээн орчуулж заншсан байна.

Л.Х.Морганы тайлбарласнаар ирокез овгууд нь өөрийн гэсэн газар нутаг, хэл аялага, ахлагчаа сонгох, огцруулах эрх, шашны ёслол, зөвлөл, зарим тохиолдолд ерөнхий ахлагчтай бөгөөд овог нь дотроо ахлагч, зөвлөл бүхий “ген” буюу “клан” хэмээх эцгийн шугам дагасан ураг төрлийн дэд нэгжүүдэд хуваагддаг бол дайтах гэх мэт онцгой цаг үед дээшээ зохион байгуулалтад орж, “сэцэд болон ахлагчдын зөвлөл” бүхий эрх тэгш овгийн сулхан холбоог үүсгэдэг байна (Morgan 1877: 61-62, 105-132). Мөн тэрээр “бүдүүлэг” нийгмийн байгуулалтай ирокезчүүд нь улс төрийн хувьд сайндаа л овгийн холбоо үүсэхээс бус, дээрээс шууд захирах төр, засаг захиргааны тогтолцоогоор зохион байгуулагдах боломжгүй байсан гэж үзжээ.

Өрнөдийн судлаачид Төв Азийн монгол мэтийн нүүдэлчин ард түмний нийгмийг дээрх загвараар тайлбарлаж ирсэн байна. Тэдний

үзэхээр НТӨ III зуунд Хүннү гүрэн байгуулагдсан нь хүннү нар ирокезчуудын адил “овгийн холбоо” үүсгэсэн хэрэг ажээ. Үүнээс үүдэн Хүннү гүрнийг 24 овог буюу аймгийн холбоо, шаньюйг нь сэцдийн болон ахлагчдын зөвлөл бүхий овгийн холбооны ерөнхий ахлагч байсан гэх ойлголт өнөөгийн монголчуудад ч өргөн тархжээ. Хожим XIII зуунд Чингис хаан овог, аймаг буюу тархай бутархай ураг төрлийн бүлгүүдийг нэгтгэснээр Монголын эзэнт гүрнийг байгуулсан байна. Гэтэл нүүдэлчдийн энэ түүхээс төрийн өмнөх үеийн бүдүүлэг нийгмээс агуу эзэнт гүрнүүд хэрхэн төрөн гарах билээ гэсэн хачирхалтай асуулт урган гарчээ. Өрнөдийн судлаачид уг асуултад дараах хариултыг олжээ: Төв Азийн нүүдэлчдийн нийгэм нь өөрөө төр байгуулах боломжгүй учир тэд эзэнт гүрэн байгуулахдаа төвлөрсөн засаглал, засаг захиргааны аппарат бүхий зохион байгуулалтыг хөрш зэргэлдээ суурин иргэншлүүдээс түр зээлдэн авдаг байсан бөгөөд эзэнт гүрэн задрах үед тэд эргээд ураг төрлийн зохион байгуулалтад шилждэг ажээ. Иймд “зээлдмэл төр” нь ураг төрлийн нийгмийг өөрчлөөгүй төдийгүй өөрчлөх ч боломжгүй ажээ.

Д.Снийт (2007), Л.Мөнх-Эрдэнэ (2012) нарын өгүүлснээр XIX зуунд Өрнөдөд үүсэн хөгжсөн антропологийн хувьслын онол ба түүний Зөвлөлт хувилбараар монголчуудын түүх, нийгмийн байгууллыг судлах онол-аргазүйг Монголын хөрсөнд буулгахад Орост орчин цагийн европ боловсрол эзэмшсэн Жамсрангийн Цэвээн, Бямбын Ренчин нарын буриад сэхээтнүүд чухал үүрэгтэй байжээ. Д.Снийтийн бичсэнээр XX зууны эхээр Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөний нөлөөгөөр монголчуудын үндэсний үзлийн шинэ ойлголт бий болсон ч энэ нь ураг төрлийн овогч үзэл (tribalism)-д суурилсан бөгөөд түүний гол үндэслэгч нь Хаант Оросын нийслэл Санкт-Петербургт боловсрол эзэмшсэн буриад сэхээтэн Ж.Цэвээн ажээ. Тэрээр монгол үндэстний ойлголтыг шинээр томъёолохдоо Европын үзлийг Монголын хөрсөнд буулгаж, монголчуудын нийгмийн зохион байгуулалтын нэгжүүдийг “tribe” буюу орос хэлний “племена” болгон орчуулжээ (Sneath 2007: 172). Улмаар түүний гаргасан жимээр овогч үзэлд суурилсан түүх, угсаатны судалгаанууд хийгдэх болж, төрийн өмнөх шатны ураг төрөл овгуудаас үүссэн Халх, Дөрвөд, Буриад гэх мэт бүлгүүдийг багтаасан Монголын “угсаатны бүрэлдэхүүн”-ийг тодорхойлжээ.

Ийнхүү Өрнөдөд боловсорсон нийгмийн хувьслын онол ба түүнд суурилсан түүх, угсаатны судалгааны нөлөөгөөр монголчууд нь түүхийн хувьд төр, засаг захиргаа бус, харин эцгийн шугмыг дагасан ураг төрлийн “овог”-ийн байгуулалт нийгэмтэй байсан гэх үзэл хэвшин тогтсон байна. Тэрхүү үзлээр Монгол дахь Халх, Урианхай, Буриад, Дөрвөд, Баяд, Барга гэх мэт угсаатнууд нь эцгийн шугам дагасан ураг төрлийн нэгдэл бүхий эртний овгуудаас гаралтай бөгөөд тэднийг судалдаг түүх, угсаатан судлалын гол чиглэл нь тухайн угсаатны насыг аль болох эртний үед холбогдуулан тогтоох, түүний

бусдаас ялгарах хэл аялгуу, бэлгэдэл, өвөрмөц зан заншил, ёслол, найр наадам зэргийг тодорхойлох, тэр нь бусад угсаатнаас ямар ямар ялгаатай болохыг аль болох тодруулан гаргах ажил болж хувирсан байна. Энэ мэт судалгаа нь онол, аргагүйн хувьд XIX зууны антропологич Л.Х.Морган ирокезчүүдийн овог (tribe) гэх ураг төрлийн нэгдлүүдийг хэд хэдэн шинжээр нь тодорхойлж байсныг хуулбарлан дуурайжээ.

Дээрх ойлголтоор авч үзвэл, Монгол дахь зарим угсаатан Монголын эзэнт гүрнээс ч хэдэн зуун жилийн урт настай байхад зарим нь саяхан үүссэн, эсвэл нэг угсаатны доторх дэд бүлгүүдийн үүсэл гарвал нь мянган жилээр зөрөх тохиолдол гарах болсон байна. Жишээ нь, Буриад угсаатны эртний овгууд нь Байгал нуурын баруун эрэг орчимд VI зуунд үүссэн байхад зарим нь мянга гаруй жилийн дараа түүхийн тавцанд гарч иржээ. Дөрвөд угсаатныг “Монгол нууц товчоон”-д өгүүлдэг Дува сохорын дөрвөн хүүгээс гаралтай гэж тайлбарладаг бол Дарьганга нь бүр хожуу XVII зууны үед хоёр гурван угсаатны нийлбэрээс үүссэн байх жишээтэй. Энэ мэтээр Монгол дахь угсаатны түүхийн судалгаа гэгч нь тухайн угсаатны өвөг дээдэс ямар ураг төрөл, овгоос үүссэнийг олж тогтоох, үүний тулд овог үүссэн, нэг овгоос хэд хэдэн овог салбарлан гарсан, овог салсан, овгууд нэгдэн нийлсэн гэх мэт хөвөрч дуусашгүй үйл явцыг тодруулан хөөх болсон бөгөөд үүгээрээ угсаатны гарвал судлал нь нийгэм, соёлын утгатай гэхээс илүүтэй биологийн төрөл зүйлсийн ангиллын таксономи үйлдэхтэй ижил төстэй ажил болсон байна.

### **Орос, Японы гео улс төр, панмонгол популизм**

XIX зууны сүүлч, XX зууны эхээр Номхон далайн эргээс Төв Ази хүртэлх уудам бүс нутгийг колоничлохын төлөөх өрсөлдөөнд хоёр улс оржээ. Тэднийг нэг нь Европын таван их гүрний нэг Хаант Орос, нөгөө нь ахар хугацаанд шинээр аж үйдвэржиж, орчин үежсэн Япон байв. Орос, Японы санаархаж байсан Азийн уудам тэгш өндөрлөг нутаг нь Манж Чин гүрний харьяанд байсан ч үе улиран угсаа залгамжлан хүн ардаа захирсаар ирсэн монгол язгууртнуудын хувь эзэмшил хэвээр байжээ. Энэ бүс нутгийг колоничлох өрсөлдөөнд хоёр улс цэрэг, дипломатын төдийгүй үзэл суртлын үйл ажиллагааг идэвхтэй явуулах болсон байна. Тэрхүү үзэл суртлаас “панмонголизм” төрөн гарч, хожим панмонгол буюу нармай монгол популизм болон дэлгэрчээ. Панмонгол үзэл нь орчин үежээгүй, тархай бутархай, хэл соёл нэгтэй монгол овог аймгуудыг нэгтгэх, гэхдээ тэрхүү нэгдлийг орчин үеийн иргэншсэн гүрний ивээлээр гүйцэлдүүлэх учиртай хэмээн номлосон байна.

Хаант Оросын зүгээс явуулсан панмонгол бодлого нь монголчуудтай хэл, шашин соёл нэгтэй боловч европ зүгийн сургуулиар боловсорч хүмүүжсэн, монголчуудыг бодвол илүү “иргэншсэн” буриад сэхээтнүүдээр дамжин хэрэгжжээ. Тэдний гол

төлөөлөгчид нь Хаант Оросын харьяат Петр Бадмаев, Агваан Доржиев, Элбэгдорж Ринчино нар байв. Буриадууд хэл, шашин нэгт монголчуудтай ойр байдгийн хувиар Оросын эрх баригчдад Монгол, Төвөдийн талаарх мэдээлэл, зөвлөгөө өгч, гадаад харилцаа хийгээд Халх, Өвөр Монгол дахь угсаатан, газарзүйн судалгааны үйл ажиллагаанд биечлэн оролцох болжээ. Судлаачдын үзэхээр Хаант Оросын харьяат буриад сэхээтнүүд нь Оросыг монголчуудтай холбох чухал боловсон хүчин болсон байна.

Монгол хэлэнд “нармай монгол үзэл” хэмээн орчуулж буй “панмонголизм” хэмээх нэр томъёо нь XIX зууны Хаант Оросын сэтгэгч В.Соловьёвын “Панмонголизм” (1894) хэмээх шүлэгт анх гарчээ. Тэрхүү шүлэг нь монголчуудын тухай бус, харин Европ, Оросын соёл иргэншлийг Дорнын шар арьстнуудын аюул царцааны нүүдэл мэт нөмрөх гэж буйг зөгнөн анхааруулсан утгатай ажээ. Гэтэл “панмонголизм” нь удалгүй Оросын харьяат буриад сэхээтнүүдийн үзэл бодлоор дамжин Халх болон Өвөр Монголын овог аймгуудыг Оросын цагаан хааны ивээл дор нэгтгэж, түүний эзэнт гүрний нөлөөнд оруулах улс төрийн бодлогод үйлчилсэн үзэл суртлын зэвсэг болж хувирчээ. Эрдэм шинжилгээний хүрээнд панмонголизм нь угсаатан судлалын парадигм болсон бөгөөд үүгээр монгол нь “арьстны”, “угсаатны”, “соёлын” категори, өөрөөр хэлбэл байгалийн түүхийн бүтээгдэхүүн болсон төдийгүй нийгмийн хувьслын онолын дагуу “угсаатан-ард түмний” хөгжлийн төр улсын өмнөх шатруу хуваарилагдаж, овог аймгийн зохион байгуулалттай болжээ” (Мөнх-Эрдэнэ 2012: 31-32).

XIX зууны сүүлчээр Оросын эрх баригчдад маш ойр байсан хоёр буриад сэхээтэн бол төвөд эмнэлгийн эмч Петр Бадмаев, лам Агваан Доржиев нар юм. 1890-ээд онд засгийн газрын эрх баригчидтай ойр шадар болсон Петр Бадмаев Манжийн төр удахгүй болсон гэж үзээд, Сибириэс Монгол, Ганьсугаар дайруулан Төвөд хүртэл төмөр зам тавих төлөвлөгөөг эрх баригчиддаа танилцуулж, Монгол, Хятад, Төвөдийг Оросын эзэнт гүрэнд нэгтгэх санал гаргасан ба Орос нь Азийн овог аймгуудыг “иргэншүүлэх” үүрэг хүлээсэн улс мөн гэж үзэж байжээ. Бадмаев нь Монгол, Төвөд, Хятадыг Оросын бүрэлдэхүүнд нэгтгэх өөрийн санаачилгыг “буриадын үндэсний үзэл”-тэй хослуулан Орос бол Чингис хааны байгуулсан Монголын эзэнт гүрний шууд залгамж мөн гэх үзэл суртлаар зөвтгөж, монгол мэтийн буддын шашинт ард түмнүүд Оросын өгөөмөр ивээлийг хүртэх ёстой үзсэн бол Төвөдөд XIII Далай ламтай шадарлаж байсан Агваан Доржиев нь “Буриад-Халимаг панмонгол үзэл”-ийг буддын шашны үзэл сурталтай хослуулан монгол мэтийн буддын шашинт ард түмнүүдийг Цагаан хааны ивээлд багтаах талаар номлож байжээ (Laguette 2008: 117-122).

Гэвч Алс Дорнодод Солонгосын хойг хүртэл өргөжин тэлэх гэсэн Хаант Оросын бодлого нь 1904-1905 оны Орос-Японы дайнд ялагдсанаар сүйрсэн байна. Уг үйл явдлаар хаант Оросын гадаад

бодлого өөрчлөгдөж, нийт монгол овог аймгуудыг Цагаан хааны ивээл дор нэгтгэх гэсэн санаархал замхарчээ. Харин Европын хүчирхэг гүрнийг ялсан Япон нь Солонгосын хойг, Өмнөд Манжуур, Өвөр Монголын зүүн хэсэгт нөлөөний хүрээгээ өргөжүүлсэн төдийгүй цааш өргөжин тэлэх санаархал нь улам хүчтэй болсон байна. Удалгүй 1914 онд Дэлхийн I дайн эхэлж Орос дайнд орсноор эзэнт гүрэнд бүр том өөрчлөлт гарав. 1917 онд Орост хувьсгал гарч хаант засаг унасан ба улс төрийн хямрал даамжирсаар улмаар коммунистууд засгийн эрхэнд гарч, Зөвлөлт улс байгуулагджээ.

Зөвлөлт улс байгуулагдаж, Орост иргэний дайн дэгдсэнээр панмонгол үзэл нь Алс Дорнод дахь улс төрийн хүчнүүдийн тоглолтын үзэл суртлын зэвсэг болж хувирсан байна. 1918 онд цагаантны генерал, буриад цустай Г.М.Семёнов Байгалын чанадад өөрийн дэглэмийг тогтоосны дараа Японы дэмжлэгээр монгол цэргийн хүчээр Зөвлөлт засгийг эсэргүүцэн тэмцэх, ингэхдээ панмонгол үзлийг ашиглан монголчуудаас аль болох олон цэрэг татаж, томоохон арми байгуулахын тулд Буриад, Барга, Халх, Өвөр Монголыг нэгтгэсэн “Их Монгол Улс”-ыг байгуулж буйгаа зарлав. 1919 оны II сард Г.М.Семёнов Читад Буриад, Барга, Өвөр Монголын төлөөлөгчдийг оролцуулсан монгол овогтны их хурал гэгчийг хийж, Буриад, Барга, Халх, Өвөр Монголыг тэгш эрхтэй нэгтгэсэн холбооны улсыг тунхаглаж, түүний засгийн газрыг Өвөр Монголын Нэйсэ гэгээн Мэндбаяраар толгойлуулан байгуулжээ. Гэвч Нармай Монгол улс байгуулах үйл ажиллагаанд Богд хаант Монгол улсын засгийн газар оролцоогүйгээр барахгүй Халхын язгууртнууд түүнээс ихэд болгоомжилж, хэрэв Г.М.Семёновын саналыг хүлээн авбал Монгол улсын статусыг хүлээн зөвшөөрсөн олон улсын гэрээг зөрчсөн үйлдэл болно гэж үзсэн байна.

Хожим Монгол дахь Коминтерний төлөөлөгч болсон буриад сэхээтэн Э.Ринчино панмонгол үзэлт хөдөлгөөнд идэвхтэй оролцож, Нармай Монголын засгийн газрын зөвлөхөөр ажиллажээ. Гэвч удалгүй цагаантнууд ялагдаж, Японы дэмжлэг үгүй болсноор Нармай Монгол улс байгуулах хөдөлгөөн сарнижээ. Э.Ринчино 1920 онд Монголын төлөөлөгчдийг Зөвлөлтийн эрх баригчдтай холбоход тус дэм болсныхоо ачаар Зөвлөлтийн бодлогыг Монголд хэрэгжүүлэх хэд хэдэн албан тушаалд удаа дараа томилогдсон байна.

Э.Ринчино Хаант Оросын үеийн панмонгол популизмыг буриадуудын дотор идэвхтэй ухуулж байсан бол Зөвлөлт засгийн үед түүнийгээ Зөвлөлтийн угсаатны бодлогод нийцүүлэх байдлаар тайлбарлаж эхэлсэн бололтой. Тэрбээр Монголыг “зөвлөлтжүүлэх”-ийн тулд Буриад, Монголыг ойртуулах замаар Монголыг Зөвлөлт улсад нэгтгэх саналыг дэвшүүлсэн байна. О.Батсайханы хэвлүүлсэн Оросын архивын нэгэн баримтаас үзвэл, Э.Ринчино 1922 онд Оросын Коммунист Намын Буриадын хороонд Монголын талаар бичсэн илтгэлдээ “Монгол, Буриадын бүгд найрамдах улсын эдийн засгийг холбох замаар ойртуулах асуудлыг боловсруулж тавих цаг нэгэнт

болжээ. Эдгээр асуудлуудыг цаг хугацааг нь тааруулж, тавьж шийдвэрлэх аваас одоогийн улс төр эдийн засгийн хөгжлийн үр дүнд Монгол зөвлөлтжих замд эргэлт буцалтгүй орох ёстой ба ойрын ирээдүйд ЗСНБХУ-ын шинэ гишүүн болох нь дамжиггүй” (Батсайхан 2007: 188) гэжээ.

Япон бүр XIX зууны сүүл үеэс Солонгосын хойгт чиглэсэн бодлого явуулахын зэрэгцээ Халх, Өвөр Монголыг ихээхэн сонирхон судалж байжээ. Япончууд 1904-1905 оны дайнаар Оросыг ялж, Өвөр Монголын зүүн хэсэгт нөлөөгөө тогтоосон ч дайны дараах Орос-Японы хэлэлцээрээр Халх нь Оросын нөлөөний хүрээнд үлдсэн аж. Гэвч Манжуур дахь Японы цэргийнхэн Халх дахь улс төрийн байдлыг тун анхааралтай ажиглаж байжээ. Л.Жамсрангийн судалгаанаас үзвэл, 1919 онд Япон нь панмонгол хөдөлгөөнийг дэмжиж, Нармай Монголын Засгийн газарт зээл олгохоор амласан ч тус хөдөлгөөн амжилт олохгүй нь тодорхой болох үед амалсан зээлээсээ татгалзсан байна.

Гэвч Япон Алс Дорнодод Зөвлөлт улстай сөргөлдөх хэрээр Монголын асуудлыг улам анхаарч байсан нь мэдэгддэг. 1939 онд Японы судлаач Т.Асано “Манж, Ар Монголыг нэгтгэх нь: Түүх, газарзүйн судалгаа” өгүүлэлдээ газарзүйн хувьд Ар Монголыг Өвөр Монголоор дамжуулан нэгтгэхээс илүүтэй Манжго-той нэгтгэсэн нь хялбар болох тухай санал дэвшүүлж, “Ар Монгол нь говийн их элсэн цөлөөр зааглагдах тул Монголын хязгаарын засгийн газартай нэгдэхэд хялбар бус, харин Манжго болон Ар Монголыг нэгтгэх нь түүх, газарзүйн хувьд зохистой тул зүй ёсны болно” (Ёшида 2025: 141) гэж бичиж байжээ. Үүнээс үзвэл, япончууд Ар Монголыг Өвөр Монголын Дэ вангийн (Дэмчигдонров) тэргүүлсэн Монгол хязгаарын өөртөө засах холбоот засгийн газар, эсвэл Манжготой нэгтгэж, эрхшээлдээ оруулах тухай сэдвийг хөнддөг байжээ.

Панмонголизм нь нэр томъёоны ч, утга агуулгын ч хувьд хилийн чанадад үүсэн боловсорч, их гүрнүүдийн зүгээс Монголыг эзлэх эсвэл өөрийн нөлөөний хүрээнд оруулах гэсэн улс төрийн зорилго бүхий угсаатны үзэл суртлын хэрэгсэл болж байжээ. Ялангуяа тэрхүү үзэл суртал нь Орост монголчуудын түүхийг төрт нийгмийн бус, харин бүдүүлэг үедээ үлдсэн, эрт цагт ураг төрлүүдээс салбарласан хэл, шашин нэгтэй олон овог аймаг гэх мөнөөх л дорно дахины талаарх Европын түүх, угсаатны үзлээр харж байсны илрэл бөгөөд тэднийг иргэншлийн дор хурааж өөрийн нөлөөнд оруулахад иргэншиж боловсорсон садан төрөл ард түмнийх нь хэлхээ холбоог ашиглах учиртай ажээ. Панмонголизм нь Монголыг эрхшээлдээ оруулж, өргөжин тэлэх гэсэн Орос, Японы санаархалд төдийлөн ач тусаа өгөөгүй боловч хожим хөрш улсуудаа буруутгах популизм болж Монголд ул мөрөө үлдээжээ.

### **Зөвлөлтийн бодлого, түүний үр дагавар**

Монголын язгууртнууд Манжийн хаант төрийн харьяанд байх үед өнөөгийн Монгол улсын нутагт амьдарч байсан хүн өөрийгөө Манжулсын иргэн, эсвэл хоёрдмол утгагүйгээр монгол үндэстэн, эсвэл том гүрний харьяанд буй угсаатны цөөнхийн гишүүн гэж хэлэх боломжгүй байв. Иргэд нь эрх тэгш байх үзэл суртал бүхий төр тэр үед бүрэлдээгүй байсан бөгөөд өнөөгийн адил үндэстэн-улсын иргэн болсноор тэрхүү үндэстний гишүүн болох боломж тэр хүнд үгүй байжээ. Манжийн үед амьдарч байсан хүн өөрөө язгууртан биш л бол ямар нэг тайж, ноёны харьяат хамжлага байх ба тэр эзэн нь өөрөө засаг ноён бүхий хошуунд харьяалалтай байна. Тэр хүний эзэн ноён бас дээрээ эзэнтэй байх бөгөөд тэр нь Манжийн хаан байна. Монголчууд Манжийн харьяанд байсан гэдэг ч үнэндээ Монголын язгууртнууд Манжийн хааны харьяат байсан ажээ. Ингээд тэр хүний ижилсэл буюу “таних үнэмлэх” нь аль улсын иргэн, ямар үндэстэн бэ гэдгээр бус, харин аль хошуу, аль аймаг, чуулганы ноёны харьяат вэ гэдгээр тодорхойлогдож байв.

XX зууны эхээр монголчууд тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэх явцад орчин цагийн үндэсний үзлийн асуудал шинээр тавигдсан байна. Ялангуяа 1921 оны VII сард Монголд шинэ засгийн газар байгуулагдаж, улмаар 1922 онд хамжлагат ёсыг халснаар үндэстэн, угсаатны шинэ асуудал гарч ирсэн байна.

Өгүүлэн буй цаг үед Монгол дахь орчин цагийн үндэсний үзлийн суурийг тавилцсан сэхээтэн бол Жамсрангийн Цэвээн юм. Д.Снийтийн тэмдэглэснээр Ж.Цэвээн нь монгол үндэсний ойлголтыг шинээр бий болгохдоо шинэ тулгар улс нь нийтлэг хэл, угсаа, шашин, суртал, газар орон бүхий хүмүүсээс бүрэлддэг гэж үзээд, монголчуудын угсаа гарвалыг мөнөөх л хувьслын онолд суурилсан Европын үзлээр харжээ (Sneath 2007: 172). Түүний тайлбарласнаар энэ нь монгол язгууртны ураг төрлийг нийгмийн доод хэсэг рүү өргөжүүлж, язгууртнууд нь өөрсдөө нэг угсаа гарвалтай ард түмний улс төрийн категорын гишүүд болж хувирсан бөгөөд Монгол улсын доторх халх, дөрвөд гэх мэт хуучин язгууртан эзний харьяанд байсан улс төр захиргааны нэгжүүд нь цусан төрлийн хувьд нэг гарвалтай хүмүүсийн нэгдэл буюу ураг төрлөөрөө нэгдсэн төрийн өмнөх шатны овгуудтай адил утгаар ойлгогдох болсон байна. Улмаар “овог” гэгдсэн тэдгээр нэгжүүд нь тус тусдаа өөрийн хэл аялага, соёл, зан бүхий “угсаатнууд” болж хувирсан байна.

1920-иод онд Монголын нийгэм-эдийн засгийг Зөвлөлтийн загварт нийцүүлэх гэсэн улс төрийн бодлого улам хүчтэй хэрэгжиж эхэлсэн бөгөөд энэ нь Монголд хэрэгжсэн угсаатны бодлогод тусгалаа олжээ. Зөвлөлт нь өөрөө олон угсаатны улс байв. “1920-иод оны сүүлээр “Зүүнтэн” гэх шинэ эрх баригчдын зүгээс Коминтерн, Зөвлөлтийн бодлогыг дуурайн хэрэгжүүлсний нөлөөгөөр Монголыг олон угсаатантай болгох үзэл төрийн бодлого, эрдэм шинжилгээ,

боловсролын системд нэвчиж, Монголчуудыг “угсаатанчлалын дурангаар” ангилах, ялгаварлах, хуваарилах, хүмүүжүүлэх бүхэл бүтэн “угсаатанчлалын парадигмийг” бий болгож, Монголын эдүгээг нь төдийгүй өнгөрснийг нь “угсаатанчилсан” хэмээн Л.Мөнх-Эрдэнэ (2012, 26) бичжээ. Түүний өгүүлсэн нь: “Зөвлөлтөд бэлтгэгдсэн Б.Ринчен (1979), Ш.Лувсанвандан (1959) тэргүүтэй Монголын судлаачид Зөвлөлтийн угсаатны үзэл баримтлалыг улам төгөлдөршүүлж нэгэнтээ Монголд 30 шахам угсаатны бүлэг, хэдэн зуун овог, 304 зүйлийн нутгийн аялгуу илрүүлэн байршил, нутагшил, тархацыг нь тогтоож нарийвчилсан атлас хүртэл гаргасан төдийгүй, зан заншил, хэл соёлынх нь ялгааг нэг бүрчлэн бүртгэж, олон боть ном, сурах бичиг, нэвтэрхий толь, музейн үзмэр бэлтгэсэн бол Монголын соёл урлаг, боловсролын байгууллагууд нь тэдгээр угсаатны, ястны хүн амыг хүмүүжүүлэн үйлдвэрлэх болсон байна” (28-29). Монгол дахь үндэстэн угсаатны асуудлыг ийнхүү олон угсаатны Зөвлөлтийн бодлогыг дуурайн шийдэж, Монгол нь өөрөө олон угсаатны улс мэт болсон нь ноцтой үр дагавартай байжээ.

1920-иод оны сүүлчээр МАХН-ын удирдах албанд байсан Ө.Бадрах, З.Шижээ нарын бүлэг хүмүүс холбогдсон, БНМАУ-аас Дөрвөдийг тусгаарлах гэсэн нэгэн хэргийг Дотоодыг хамгаалах газар шалгасан байдаг. Энэ асуудлыг нягтлан шинжилсэн Ж.Урангуагийн (2019) судалгаанд энэ хэргийн үзэл суртлын хөрс суурь нь В.И.Лениний онолд суурилсан Зөвлөлтийн угсаатны бодлогоос улбаатай байсан нь харагдаж байна. 1917 хувьсгалын дараа дэгдсэн иргэний дайн төгсөхөд Зөвлөлт нь Хаант Оросоос олон угсаатан бүхий асар том газар нутгийг өвлөн авсан бөгөөд өмнөө тулгарсан угсаатны асуудлыг дараах байдлаар шийдсэн ажээ. Ж.Урангуагийн бичсэн нь: “Төр нийгмийн байгууллаа үндэстний-газар нутгийн зарчмаар зохион байгуулах замыг сонгосон Зөвлөлт улсын төрийн бодлого нь жижиг үндэстэн ястны хувьд маш хүнд асуудлуудтай тулгарахад хүрчээ. Тиймээс үндэстний цөөнхийн асуудал гэгч зүйл гарч ирж, түүнийг шийдэхийн тулд олон арга хэмжээ авахад хүрчээ. Тэдгээрийн нэг нь: 1930 онд Зөвлөлтийн удирдлага, хэрэв тухайн засаг захиргааны нэгжид нэгэн угсаатны хүмүүс тухайн бүс дэх янз бүрийн угсаатны хүн амын дотор 66 хүртэлх хувийг эзэлж байгаа бол тусгай засаг захиргаан-нутаг дэвсгэрийн нэгж болж болно гэсэн шийдвэр гаргажээ. Энэ нь Зөвлөлтөд угсаатны доторх нэгдлийг хангаж, нэгэн шинэлэг нийтлэг үүсгэхэд хүргэж, улмаар үндэстэн ястны хоорондох харилцаанд эерэг нөлөө үзүүлэхээс гадна тэдэнд чиглэсэн нийгэм-улс төр, эдийн засаг болон соёлын ялгааны асуудлуудыг шийдэх боломж олгон, мөн угсаатны улс төрийн байдлыг дээшлүүлэх системтэй арга хэмжээг явуулснаар угсаатныг улс төржүүлэх үйл хэргийг гүйцэлдүүлнэ хэмээн тооцож байжээ” (Урангуа 2019: 112).

Дээрх судалгаанаас үзвэл, Дөрвөдийг салан тусгаарлах хэрэгт холбогдсон Л.Лааган мэдүүлэг өгөхдөө шар Санж, Ө.Бадрах нар нь

Зөвлөлтийн угсаатны бодлого ба цөөнх ястан угсаатны эрхийг үндэс болгон ухуулга хийж байсан тухай ярьжээ. Түүний мэдүүлэгт (1928.09.17), “Бадрахаас надад ингэж хэлэв хэмээн дув дуугуй явж байтал Төгсбуйантын хошууны бөгөөд тус аймгийн Хянан байгцаагчийн төлөөлөгч Цэрэнжаваас ирсэн мэдээнд мөн хошууны шар Санжаас коммунизмын мөрийн хөтөлбөрт бага ястан улсыг тусгаар болгох хэмээсэн байдаг. Одоо манай дөрвөд тэр ёсоор тусгаар улс болбол зүгээр зүгээр гэх үгийг бусдад битүүхэн хэлж яваа хэмээсэн”, мөн “1928 оны хавар Ө.Бадрах ...Одоо манай аймаг автономит эрхтэй монголоор удирдуулсан тусгаар улс болбол СССР улстай адил болж юунд ингэж дарлагдах билээ” (Урангуа 2019: 116-130) гэсэн байна. Үүнээс үзвэл, дөрвөдийн салан тусгаарлах гэсэн явуулгын үзэл суртлын сэдэл нь олон угсаатан бүхий Зөвлөлтийн угсаатны бодлого байсан нь харагдаж байна.

XX зууны эхээр Монгол улс байгуулагдаж, тусгаар тогтнохын төлөөх тэмцлийн явцад тавигдсан үндэстний асуудал нь ийнхүү олон угсаатны улс болох Зөвлөлтийн бодлогыг хуулбарлах замаар шийдэгдэж, ноцтой үр дагаварт хүрсэн байна. Энэ нь Зөвлөлтийн судлаачид өөрийн харьяанд буй Азийн ард түмэн нь түүхийн хувьд бүдүүлэг нийгэмтэй гэж үзэж байсны адилаар монголчуудын нийгмийг төргүй, ураг төрлийн байгууллаар харсан мөнөөх л хувьслын онолд суурилсан түүх, угсаатны зүйн судалгаанд суурилж байжээ.

### **Түүхийн эндүүрлийг залруулахуй**

Сүүлийн үед гадаадын ч, Монголын ч судлаачид хүннү, монгол зэрэг нүүдэлчид нь төргүй, ураг төрлийн нийгэмтэй байсан гэх үзлийг онолын хувьд ч, түүхэн эх сурвалжаар ч хүчтэй няцаах болсон байна. Д.Снийт (2007) Европын колоничлол хийгээд нийгэм-эдийн засгийн онолуудын үзэл суртлыг шингээсэн антропологийн хувьслын онол нь XX зууны сүүл үед өөрөө хүчтэй шүүмжлэгдэж, уг онолын хүрээнд хийгдсэн судалгаанууд няцаагдаж байгаа төдийгүй Төв Азийн нүүдэлчид, ялангуяа монголчуудын нийгмийг төргүй, ураг төрлийн байгуулалтай мэтээр үзэж байгаа нь түүхэн сурвалжийг ташаарч ойлгож, тайлбарласнаас үүдэлтэй эндүүрэл гэж үзжээ. П.Дэлгэржаргал (2017)-ын үзэж буйгаар, хятад сурвалжийн мэдээнд үндэслэвэл Хүннү эзэнт гүрэн нь ахлагч бүхий 24 овгийн холбоо бус, харин шаньюй хэмээх угсаа залгамжилсан эзэн хаанаар удирдуулсан, аравтын тогтолцоонд суурилсан 24 түмт бүхий засаг захиргааны нэгжээс бүрдсэн, олон зэрэг дэв бүхий түшмэд, хууль цааз, нийгмийн дээд хэсэгтээ сурвалжит овгууд бүхий хүчтэй төвлөрсөн төртэй байсан бөгөөд тус гүрний гадаад харилцаа нь хөрш улстайгаа хил тогтоох гэрээ байгуулж, түүнийгээ чанд сахиулах хэмжээнд боловсрон хөгжсөн улс байжээ.

Д.Снийт (2007) монголчуудын нийгэмд ураг төрлийн нэгдэл, холбоо бус, харин нийгмийн эрх мэдэлтэй дээд хэсэг нь албат харьяатуудаа угсаа залгамжлан захирдаг “язгууртны дэглэмт” төр оршин байсан бөгөөд тэрхүү дэглэм нь захирах, захирагдах ёсны үзэл суртал, эзэн харьяатын ёс, хууль цааз, алба татвар, засаг захиргааны аппарат гээд төрт нийгмийн харилцааны бүхий л гол шинжүүдтэй байсан гэж үзсэн байна. Түүний тайлбарласнаар, тэрхүү язгууртны дэглэм нь төвлөрсөн төрийн засаг захиргааны тогтолцоо нуран унасан, тухайлбал Чингисийн байгуулсан эзэнт гүрэн задарсан үед ч, эсвэл монгол язгууртнууд Манж Чин улсын харьяанд орсон үед ч оршин байж, угсаа залгамжилсан язгууртнууд орон нутагт эрх мэдлээ тогтвортой хадгалж, албат харьяатуудаа хэвээр захирч байжээ. Д.Снийт орон нутгийн язгууртны дэглэм нь маш эрт, бүр Хүннүгийн үеэс оршин байсныг илтгэх арвин баримт нотолгоо байгаа талаар “Тэргүүнгүй төр” (2007) бүтээлдээ өгүүлсэн байна.

Д.Снийт монголчуудын тухай гол сурвалжуудад нийгмийн анги давхраа, язгууртны засаглал, угсаа залгамжлалтай холбоотойгоор гардаг нэршлүүдийг судлаачид нягтлалгүйгээр “tribe” хэмээн ташаа орчуулан тайлбарлаж ирснийг залруусан байна. Тухайлбал, монголчуудын овог (obog) нь ураг төрлийн нэгдэл бус, харин улс төрийн зохион байгуулалтын нэгж (political unit) болохыг тодорхойлоод, овог хэрхэн үүсдэг байсныг дараах жишээгээр тайлбарлажээ. “Монголын нууц товчоон”-д өгүүлснээр Хамаг Монголын Хабул хан өөрийн ахмад хөвгүүн Охинбархагт зүрх зориг, хүч чадалтай хэсэг эрсийг шилж өгснөөр Жүрхин овог үүссэн ба овог нь ноёлогч ураг (family, line, lineage)-ийг заасан нэр бөгөөд ноёлогч ургийнхан харьяат хүмүүстэйгээ садан төрлийн холбоогүй байсан нь Жүрхиний үүслийн жишээнээс харагддаг (Sneath 2007: 108-109). Д.Снийт улсын хан эзэн овог үүсгэж, түүндээ хүмүүсийг элсүүлж, язгуур угсаат хүүдээ өгч захируулсан тухай тус жишээгээр овог нь ураг төрлийн нэгдэл биш, харин язгууртны нийгэм дэх улс төрийн зохион байгуулалтын нэгж болохыг тайлбарлажээ. Гэвч монголчуудын ноёлогч ургийнхныг заадаг “obog” хэмээх үг нь хожим “tribe” гэх европ нэр томъёоны монгол орчуулга болж хувирчээ.

Монголчуудын нийгмийг “язгууртны дэглэм”-ээр тайлбарласан Снийтийн санаа Монголын түүхийн хожмын үйл явдлуудыг ч тайлбарлахад тусалж байна. Үүгээр авч үзвэл, ХХ зууны эхээр Богд хаант Монгол улс байгуулагдсан нь Халхын ноёдын язгууртны дэглэмээ хадгалан үлдэх гэсэн тэмцэл байсан ажээ. 1911 оны сүүлээр Халхад Богд хаант улс байгуулагдаж, улмаар Өвөр Монголын хошуудыг өөртөө нэгтгэх гэсэн бодлого нь “панмонгол” хөдөлгөөнөөс тусдаа үйл ажиллагаа байсан юм! Халхын язгууртнууд, дээд лам нар VIII Богд Жавзандамба хутагтыг эзэн хаанаар өргөмжилж Манж Чин улсаас салж, тусгаар тогтнолоо тунхагласан явдлыг гадаад хүчин зүйлсээр онцолж, тухайлбал дан ганц Хаант Оросын бодлогын

нөлөө мэтээр туйлшруулж тайлбарлах нь алдаатай бөгөөд тэрхүү үйл явдлын дотоод хүчин зүйлсийг бас ойлгож байж Богд хаант улс байгуулагдсан шалтгааныг мэдэж чадах юм.

1911 оны 10 дугаар сард Манж Чин улсад Синьхайн (Цагаагчин гахай жилийн) хувьсгал гарснаар Манжийн төр унаж, Хятадын бүгд найрамдах улс байгуулагдах нь тэртэй тэргүй “шинэ засгийн бодлого”-ыг эсэргүүцэж, Манжийн хаант төрд эргэлзэж байсан Монголын язгууртнуудад нэгэнт ойлгомжтой болсон байна. Монгол язгууртнууд Манжийн хаант төрд нэгдэхдээ урьдаар харилцан болзол тавьж, гэрээ байгуулж, өөрийн эзэмшил дэх эзэн эрхээ баталгаажуулж, харьяат ардаа захирах эрх мэдлийг хадгалсан ажээ. Гэтэл Манжийн хаант төр халагдаж, Хятадад Өрнөдийн маягийн эрх тэгш ёс тунхагласан хятад үндэстний бүгд найрамдах төр байгуулагдах нь тэрхүү “язгууртны дэглэм”-д ноцтой аюул учруулах байв.

Иймд Халхын язгууртнууд Хятадад хувьсгал ялахаас урьтан яаравчлан хөдөлж, 1911 оны 11 дүгээр сарын 30-нд Халхын Хүрээний түр засгийн газрыг байгуулж, улмаар VIII Богд Жавзандамба хутагтыг эзэн хаанаар өргөмжилсөн байна. Халхад Богд хаант улс байгуулагдсан явдал нь Халх, Өвөр Монголын чуулган, хошуудын язгууртнууд хамтдаа чуулж, шинэ төр байгуулсан хэрэг биш ажээ. М.Тачибана (2011)-ийн судалгаанаас үзэл, 11 дүгээр сарын 30-нд Халхын Хүрээний түр засгийн газар байгуулагдахад Халхын баруун хоёр аймаг болох Засагт хан, Сайн ноён хан аймаг оролцоогүй бөгөөд зүүн гарын Түшээт хан, Сэцэн хан хоёр аймгийн цөөн ноёд түүнийг байгуулсан, мөн 12 дугаар сарын 29-нд VIII Богд Жавзандамбыг хаан ширээнд залж, таван яам бүхий Богд хаант засгийн газар байгуулагдахад засгийн газрын бүрэлдэхүүнд баруун 2 аймгийн ноёдоос нэг ч хүн оролцоогүй байна. Түүний үзэхээр Хүрээний түр засгийн газрыг байгуулахад эхэндээ Халхын зүүн 2 аймаг л оролцож, харин баруун 2 аймаг нь байдлыг ажиглаж байжээ. Эхэн үедээ Богд хаант Монгол улсын эрх мэдэл зүүн гарын Түшээт хан, Сэцэн хан аймгуудаар хязгаарлагдаж байсан ба 1912 онд засгийн газрын бүтцэд Ерөнхий сайдын тушаалыг бий болгосноор Сайн ноён хан Т.Намансүрэн энэ албанд томилогдож, шинэ засагт нэгджээ (Тачибана 2011: 53, 64-69).

Өвөр Монголын хошуудыг нэгтгэх гэсэн Богд хаант Монгол улсын бодлого гадаад, дотоод нөхцөл байдлаас шалтгаалж тун амаргүй байжээ. Дээр дурдсанчлан, Богд хаант Монгол улсын Засгийн газрыг байгуулахад Халхын зүүн гарын 2 аймаг оролцож, дараа нь баруун гарын 2 аймаг нэгдсэн билээ. Харин Халхад төр байгуулахад Өвөр Монголын чуулгад, хошуудын оролцоо, харилцан болзол тохироо байгаагүй ажээ. М.Тачибанагийн үзэж буйгаар, Өвөр Монголын ноёдын эзэмшил нь Манжийн хаант төр мөхсний дараа шинээр байгуулагдсан Богд хаант Монгол улс ба Ар, Өвөр Монголын өөрийн нэг хэсэг гэж үздэг Дундад иргэн улс (ДИУ) гэсэн хоёр шинэ улсын хоорондох сул орон зай болж хувирчээ (Тачибана 2011: 159-188).

Ингээд хоёр улсын зүгээс Өвөр Монголыг өөртөө нэгтгэх гэсэн сөргөлдөөн эхэлсэн байна.

Богд хаант Монгол улс нь Халх, Өвөр Монголын язгууртнуудын харилцан гэрээ болзоогоор байгуулагдсан төр биш байсан учир тус улс нь Өвөр Монголын ноёдыг дагаар оруулж, харьяат болгох бодлогыг баримтлахаас өөр аргагүй болжээ (Тачибана 2011). 1911 оны 12 дугаар сарын эхээр Хүрээний засгийн газраас Өвөр Монголын чуулгадад дагаар орохыг ятган ухуулах бичиг илгээсэн ба өвөр монгол ноёдыг дагаар орохыг ятган ухуулахдаа “монгол овогтон” нэгдэх ёстой гэсэн үзэл суртлыг ашигласан байна. “Монголын нууц товчоон”-д өгүүлснээр “овог” нь эзэн-харьяатын харилцаанд тулгуурласан, язгууртанд захирагдсан хүмүүсийн бүлэг ажээ. Богд хаант Монгол улс Өвөр Монголын ноёдод ухуулахдаа “овогтон” гэх нэршлийг “Монголын нууц товчоон”-д өгүүлсэнтэй адилаар язгууртан эзэн ба түүний харьяат ардаас бүрдсэн нийгэмлэг гэх утгаар хэрэглэж, Өвөр Монголын язгууртнуудыг “үндэс язгуур”-аа бодож шинэ төрд дагахыг ятгасан гэж үзэж болох юм.

Гэвч 1911 оны 12 сарын эхээр Өвөр Монголын ноёдод илгээсэн, шинэ төрд дагахыг ухуулсан бичгийн хариу ирсэнгүй, бүр 1912 оны намар хүрсэн байна (Тачибана 2011: 164-172). Энэ асуудалтай холбогдуулан М.Тачибана Богд хаант Монгол улс ба Өвөр Монголын ноёдын харилцааг нарийвчлан судалжээ. Тус судалгаанаас үзвэл 1912 оны 4 дүгээр сард Өвөр Монголын Их Зуугийн чуулганы ноёдоос Монгол улсад 13 зүйлийн асуулга хүргүүлсэн бөгөөд түүнд VIII Богд Жавзандамба хаан суух нь хэр зөв болохыг, Юань улсын Юлю Чуцай, Го Юйбао нар шиг эрдэмт түшмэл бий эсэх, улсын төсөв санхүүг хаанаас гаргах, улсын нийслэл хаана байхыг лавласан байна (219-230). Энэ асуулгаас үзвэл Их Зуу чуулганы ноёд шашны хэрэг эрхэлсэн VIII Богд Жавзандамба лам нь хаан суух хууль ёсны эрхтэй эсэхэд төдийгүй ерөнхийдөө Богд хаант Монгол улсын оршин тогтнох чадавхид эргэлзэж байсныг илтгэж байна.

М.Тачибанагийн өгүүлснээр Өвөр Монголын ноёд дагаар орохыг ухуулсан бичигт хариу ирүүлэлгүй олон сар болсон тул Богд хаант засгийн газраас цэрэг илгээж Шилийн голын чуулганы дарга Янсанг баривчлан Хүрээнд ирүүлсэн ба энэ явдлаас хойш Өвөр Монголын ноёдод ухуулах бус, харин “үндэс язгуураа бодохгүй” гэх зэргээр зэмлэж тулган шаардах арга зам руу орсон ажээ (Тачибана 2011: 164-172). Энэ ажиллагааны үр дүнд Өвөр Монголын 49 хошууны 35 нь ямар нэг байдлаар дагаар орох бичиг ирүүлсэн байна (159). Гэвч ДИУ-ын Засгийн газар Өвөр Монголд мөн л өөрийн бодлогыг хүчтэй тулгаж, өвөр монгол ноёдын цол, зэрэг, эрх мэдлийг хэвээр үлдээж, эд мөнгө шагнал амлаж аргадахын зэрэгцээ сүрдүүлэх, тулган шаардах бодлогыг хослуулан явуулж байжээ. М.Тачибанагийн үзэж буйгаар, Өвөр Монголд хоёр талаас явуулсан бодлого нь 1913 онд “Таван замын байлдаан” гэгдсэн зэвсэгт мөргөлдөөнд хүргэсэн байна.

М.Тачибана (2011) судалгаандаа шинэ байгуулагдсан Богд хаант Монгол улсын хүч нөлөөг дутуу үнэлж болохгүй юм гэж дүгнэжээ. 1919 онд Монгол улсын автономит эрх эвдэгдсэн нь Монголын эрх баригчид ДИУ-аас айж сүрдсэн гэхээс илүүтэй 1917 онд Орост гарсан хувьсгалаас айн болгоомжилсноос шалтгаалжээ. Хэрэв Оросын хувьсгалын нөлөө Монголд нэвтэрвэл олон зуун жил тогтносон язгууртны дэглэм нь мөхнө гэдгийг Халхын язгууртан ноёд сайн ойлгож байжээ. 1911 онд монгол язгууртнууд Богд хаант Монгол улсыг тунхаглаж, төрөө хамгаалсан боловч 1917 оны Оросын хувьсгалаас дэглэмээ аврахаар улсынхаа автономит эрхээр “оролдсон” нь “1921 оны хувьсгал”-д хүргэж, орчин үеийн улсын үндэстэн, угсаатны асуудал шинээр тавигджээ.

### **Дүгнэлт: ‘Угсаатан’ төрийн бүтээл болох нь**

Монгол дахь “угсаатан” гэгдэж буй бүлгүүд хэзээ, юунаас үүссэн бэ? Тэд аяндаа цаг хугацааны эрхээр үүссэн үү, эсвэл тэднийг дээрээс зориуд бий болгосон уу? Өөрөөр хэлбэл, тэд биологийн төрөл зүйл адил салбарлан үржсэн үү, эсвэл төр тэднийг бүтээсэн үү?

Хэрэв орчин үежилтээс өмнө Монголд төргүй, овгийн байгуулалт нийгэм оршин байсан юм бол Монгол дахь угсаатнууд нь тус тусдаа овгуудаас салбарлан үржсээр өнөө үе хүрсэн хүн амын бүлгүүд байх учиртай аж. Дарвинизмд суурилсан овогч үзлээр харвал ийм угсаатнуудыг төрт нийгмийн түүхээр харах боломжгүй бөгөөд овог, аймаг болж үүссэн, салбарласан, эсвэл тэдгээр нь мөхөж үгүй болсон үйл явцаас өөр үзэгдлийг тэдний үндсэн түүхээс бараг олж үзэхгүй ажээ. Хэрэв эртний бүдүүлэг үедээ “гацсан” тэдний нийгэмд төрийн аппарат үүсэж, нийгэм, соёлын дэвшил гарсан бол тэр нь гадаад ертөнцөөс хуулбарлан авсан байх ёстой гэнэ.

Сүүлийн үед эрдэмтдийн судалгаа нь овогч үзлээр монголчуудын улс төр-нийгмийн байгууллыг тайлбарлаж ирсэн нь буруу болохыг илрүүлж байна. Тэдний судалгаанаас үзвэл Монгол нутагт Хүннү гүрний үеэс төрт нийгэм оршсоор ирсэн бөгөөд нүүдэлчдийн улс төр-нийгмийн зохион байгуулалтын нэгжүүд төдийгүй соёл, шашин шүтлэг, зан заншлын өөрчлөлтүүд нь төрөөс хамаарч байжээ. Үнэн хэрэгтээ Халх, Буриад, Дөрвөд, Баяд, Захчин, Торгууд, Дарьганга, Урианхай гэх мэт “угсаатнууд” нь түүхийн явцад дээрээс буюу төрөөс зохион байгуулсан засаг захиргааны нэгжүүдээс үүссэнийг судлаачид тогтоосон байна. Тухайлбал, Халх нь XV зууны Монголын засаг захиргааны нэгж болох 6 түмний нэг байсан бөгөөд өнөөгийн Монгол улсын халх нар XVI зуунд Даян хааны отгон хүү Гэрсэнзэд хувь болгон олгосон хошуудаас үүсжээ. Ховд аймгийн Захчин нь хилийн харуулын албыг хариуцсан Зүүнгарын засаг захиргааны нэгж (отог)-ээс үүссэн байна (Sneath 2011: 174). Сүхбаатар аймгийн Дарьганга нь XVII зуунд Манжийн хааны хувийн мал сүргийг адгуулах албанд хошуудаас хүмүүсийг татаж байгуулсан шинэ засаг

захиргааны нэгж байжээ. Монголын “угсаатнууд” нь өөр өөр цаг үеийн төр засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлтийн үр дүн ажээ. Өөрөөр хэлбэл, тэд манай түүхэнд ямар төр, ямар бодлого, ямар засаг захиргааны зохион байгуулалт байсны толь болох юм.

1921 онд Монголд шинэ засгийн газар байгуулагдсанаар хувьсгалт өөрчлөлт эхэлжээ. Засгийн газар 1922 онд хамжлагыг халснаар Монголд эзэн-харьяатын ёс үгүй болов. Тэр цагаас хойшхи төрийн бодлого, засаг захиргааны зохион байгуулалтын шинэчлэлээр язгууртан ноёдын хувь эзэмшлүүд болон өртөө, харуулын албаны зэрэг засаг захиргааны нэгжүүд нь үндсэн хуулиндаа жирийн ард олны эрх, тэгш ёсыг тунхагласан бүгд найрамдах улсын засаг захиргааны зохион байгуулалтаар халагджээ.

XIX зуунд “Мэйжийн шинэчлэл”-ээр Японд хуучны ёсыг халж, язгууртны эзэмшлүүдийг засаг захиргааны шинэ зохион байгуулалтаар өөрчилж, орчин үеийн япон үндэстнийг бүтээжээ. XX зууны эхээр Османы эзэнт гүрэн мөхмөгц түүний ормон дээр бүгд найрамдах улс шинээр байгуулагдаж, орчин үеийн турк үндэстний ижилсэл буй болжээ. Гэтэл XX зууны эхээр “орчин үежсэн” гэж түүхчид, нийгэм судлаачид нь тунхагладаг Монгол улсад төргүй нийгмийн овгуудын үргэлжлэл болох “угсаатнууд” хэвээр үлдэж, бүр XXI зуунтай золгожээ.

## Ном зүй

- Алтанмандах, Б., Ч. Гажиддулам, Э. Гэрэлт-Од, О. Өнөрцэцэг, О. Пүрэв, Ц. Сэлэнгэ, С. Түмэндэлгэр. 2019. *Нийгэм судлал Х. Улаанбаатар*: Боловсрол, Шинжлэх ухааны Яам.
- Батсайхан, О. 2007. *Монгол үндэстэн бүрэн эрхт улс болох замд (1911–1946)*. Улаанбаатар: Адмон.
- Болд, Л., et al. 2015. *Монгол хэлний их тайлбар толь*. [https://mongoltoli.mn/search.php?ug\\_id=69149&opt=1&word=%D0%9E%D0%A0%D0%9E%D0%9D#](https://mongoltoli.mn/search.php?ug_id=69149&opt=1&word=%D0%9E%D0%A0%D0%9E%D0%9D#).
- Дэлгэржаргал, П. 2017. *Монголын эртний түүх. I боть: Хүннү*. Улаанбаатар: Соёмбо Принтинг.
- Ёшида, Ж. 2015. *Японы Монгол судлалын түүх*. (орч.) О.Оюунжаргал. Улаанбаатар.
- Laruelle, Marlene. 2008. “‘The White Tsar’: Romantic Imperialism in Russia’s Legitimizing of Conquering the Far East.” *Acta Slavica Iaponica* 25: 113–134.
- Morgan, Lewis Henry. 1877. *Ancient Society; or, Researches in the Lines of Human Progress from Savagery through Barbarism to Civilization*. Chicago: Charles H. Kerr & Company.
- Мөнх-Эрдэнэ, Л. 2025. “Монгол үндэстэн геноцидын тавцанд: Монгол ба БНХАУ-ын үндэстний бодлого дахь монгол үндэстэн.” *Mongolian Anthropological Review* 1 (1): 23–38.

- Мөнх-Эрдэнэ, Л. 2012. “Монголын тусгаар тогтнолын ёгт үр дагавар: Монголчуудыг монголжуу, Монгол улсыг олон ястны болгосон нь.” In *Монголын тусгаар тогтнол ба монголчууд: Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл*, edited by С. Чулуун, 25–40.
- Sneath, David. 2007. *The Headless State: Aristocratic Orders, Kinship Society and Misrepresentations of Nomadic Inner Asia*. New York: Columbia University Press.
- Урангуа, Ж. 2019. “Шар Санжийн хэрэг: Дөрвөдийг тусгаарлах хэмээсэн хэргийг нэхэн шинжихгүй.” In *Монгол судлалын өгүүллүүд*, edited by Ж. Баясах and Ж. Урангуа, 109–130. Улаанбаатар: Монлойс.